



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 01 сарын 12 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Концессын “барих-шилжүүлэх” төрлөөр барьж ашиглалтад оруулсан нийт 10,686,414,530.00 (арван тэрбум зургаан зуун наян зургаан сая дөрвөн зуун арван дөрвөн мянга таван зуун гучин) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу орон нутгийн (Нийслэл, Баянхонгор, Төв) өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Үндэсний хөгжлийн газрын дарга Х.Батжаргал, Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын дарга н.Баяраа, Баянхонгор аймгийн Өмчийн газрын дарга н.Идэрмөнх, Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Д.Батжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт концессын “барих-шилжүүлэх” гэрээгээр бий болсон хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, эзэмшигч байгууллагыг тогтоох асуудлыг Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулан шийдвэрлэх

2.2. Хөрөнгийг зохих хууль, тогтоомж, журмын дагуу эзэмшигч байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д оруулан бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс /Д.Нарангэрэл/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.НАРАНГЭРЭЛ

D:\Huraldaanii material\2021 on\2021.01.12 1r huraldaan.docx

13201787

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021
оны 01 дүгээр сарын 4-ны өдрийн 09 дугаар
тогтоолын хавсралт

КОНЦЕССЫН "БАРИХ-ШИЛЖҮҮЛЭХ" ГЭРЭЭГЭЭР БИЙ БОЛСОН, ОРОН НУТГИЙН
ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Барилга байгууламж /хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ/-ний нэр	Хөрөнгийн үнэ (төгрөг)	Орон нутгийн өмчид хүлээн авч бүртгэх, аймаг нийслэлийн нэр
1	Аглаг бүтээлийн хийд хүртэлх 6.2 км хатуу хучилттай авто зам	6,958,000,000.0	Төв аймгийн Орон нутгийн өмчийн газар
2	38 дугаар сургуулийн барилга /Улаанбаатар хот Баянгол дүүрэг, 38 дугаар сургуулийн барилга/	2,587,900,000.0	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар
3	100 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөлийн барилга /Баянхонгор аймаг, Өлзийт сум/	1,140,514,530.0	Баянхонгор аймаг Орон нутгийн өмчийн газар
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	10,686,414,530.00 (арван тэрбум зургаан зуун наян зургаан сая дөрвөн зуун арван дөрвөн мянга таван зуун гучин)	-